

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

ЗОРИЛТ	Сумын ЗДҮАХ- ийн арга хэмжээний тоо	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо	100	70	40	0	ҮБ	Хувь
НЭГ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭ	3	22	10	8	1	-	3	84.2
ХОЁР. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮНС ХУДАЛДААНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:	3	39	24	9	3	0	3	87.5
ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭ	5	27	11	14	1	0	1	81.5
ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ	5	56	36	13	2	1	4	88.2
Дүн	16	144	81	44	7	1	11	86.17

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

САЙНЦАГААН

2020.12.10

НЭГ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭ

№	Хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжилт	хувь
1.Төрийн албаны стандартыг мөрдүүлж, албан хаагчдыг сургаж, чадваржуулах, тэдний ёс зүй, ажлын хариуцлагыг өндөржүүлэн, боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлнэ			
1.1.	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлэх, сахилга хариуцлагыг чангатгах арга хэмжээ авч ажиллах	Хуулийн хэрэгжилтийг бүхий л шатанд ханган ажиллалаа. Тус сумын ЗДТГазрын ХАА-н тасгийн мэргэжилтэн -2, санхүүгийн албаны мэргэжилтэн, ЗДТГазрын даргын албан тушаалын захиалгыг хүргүүллээ. Сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй.	70
1.2	Төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий бүх шатны байгууллага ажиллагсадтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээг сар, улирлаар дүгнэж, үр дүнг тооцох	Албан хаагчдын ажлын төлөвлөгөөг 7 хоног бүр гаргуулж,хэрэгжилтийг тухай бүр тооцлоо. Албан хаагчид сар бүр ажлын төлөвлөгөө,хэрэгжилтийг гаргаж,үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг тушаалаар олголоо. Харьяа байгууллагын төрийн албан хаагчид хөдөлмөрийн гэрээтэй ажиллаж,үйл ажиллагааны гүйцэтгэлээ журмын дагуу үнэлүүллээ.	100
1.3.	Сумын хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангахад санаачилга гарган ажиллах	Сумын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн дагуу байгууллагууд албан хаагчдын судалгааг, баг бүр мэргэжилтэй залуучуудын судалгааг жил бүр гаргадаг. Сумын ЗДТГазрын сул орон тооны захиалгыг хүргүүллээ.	70
1.4	Төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах болон гүйцэтгэх ажилтны томилгооны зөрчил гаргахгүй ажиллах	Албан хаагчдын томилгоог холбогдох хууль журмын дагуу хийлээ. Сумын засаг даргын захирамжаар сонгон шалгаруулалтанд тэнцсэн Хүмүүнлэг сургуулийн захирал, 6-р цэцэрлэгийн эрхлэгчийн материалыг АТГазраар хянуулан,дүгнэлтийн дагуу томиллоо.	100
2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах нөхцөлийг ханган, төрийн ажил үйлчилгээг хүргэх арга замыг боловсронгуй болгох			
2.1	www.dundgovi.gov.mn болон өөрийн цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан сумынхаа үйл ажиллагааг иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх, цаг үеийн мэдээллийг тухай бүр байршуулж мэдээллийн	Орон нутгийн мэдээ цэсэнд 44, Хууль эрх зүйн акт цэс шинээр нээлгэж, ИТХ-ын тогтоол- 13, Засаг даргын захирамж- 57, ЗДТГ-ын даргын тушаал- 11 байршууллаа. Улсын төсөв,аймгийн ОНХСан, Ссумын ОНХСан цэс шинээр нээж 18 мэдээлэл байршууллаа. Цахим мэдээллийн системийг ашиглан үйлчилгээ үзүүлэх" Төрийн үйлчилгээг операторын тогтолцоонд шилжүүлэх, систем нэвтрүүлэх" сургалтанд хэвлэл мэдээллийн ажилтан хамрагдлаа. Тус суманд 9(иж бүрэн компьютер,	100

	баяжилтыг сайжруулах	хурууны хээ уншигч, тоон гарын үсэг, уртасгагч, 3 үйлдэлт принтер, кабель, дэлгэцийн карт) төрлийн тоног төхөөрөмжийг -“ХУР”системийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээнийн хүсэлтийн бүртгэлийн хяналтын системээр нийт 379 иргэнд үйлчилгээ үзүүлээ.	
2.2	Тухайн орон нутагт зохион байгуулсан үйл ажиллагаа, удирдлагын зүгээс гаргасан тогтоол шийдвэр, хурал зөвлөмжийн мэдээллийг тухай бүр ирүүлж, аймгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сум орон нутагтаа сурталчлах	Энэ онд засаг дарга А захирамж 230 ,Б захирамж 21 ийг гаргалаа.Үүнээс иргэдтэй холбоотой 57 захирамж цахимд байршууллаа. Сар бүрийн 30 ны дотор шилэн дансанд холбогдолтой 57 захирамж,39 тушаалыг байршууллаа.	100
2.3	Иргэдтэй харилцах утас ажиллуулж, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийвэрлэх, сурталчлах	Сумын ЗДТГазрын 70592553 нээлттэй утсаар 6 иргэн хандаж 100% шийдвэрлэлээ.	100
2.4	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл,гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулах	Иргэдээс 145 өргөдөл хүлээн авснаас засаг дарга, мэргэжилтнүүдэд хандсан 53, багийн засаг даргад хандсан 92 байна. Шийдвэрлэлт 90 %-тай байна.	100
2.5	Багийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулан зохион байгуулсан ажлын тайланг улирал бүр таниулж, хийсэн ажлын мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлж хэвших	Багийн засаг дарга нартай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг нэгтэгн үр дүнг тооцлоо. Баг бүр өөрсдийн пэйж хуудсанд тогтмол мэдээлэл байршууллаа.	70
2.6	Багийн Засаг дарга нарыг унаажуулах	Тус сумын багийн засаг дарга нарын 77.7 % нь мотоцикльгүй байна.	70
2.7	Гадаад хамтын ажиллагааг орон нутагт хөгжүүлэхэд санаачлага гарган, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах	Цаг үеийн байдлаас шалтгаалан хийгдээгүй.	-
2.8	Сумдын гал унтраах сайн дурын хэсгийн үйл ажиллагааг жигдрүүлж, чадавхжуулна	Тамгын газрын даргын тушаалаар сайн дурын хэсгийг томилгоожууллаа.Сургалт төлөвлөгдсөн боловч хийгдээгүй.	40
2.9	Өсвөрийн аврагч бүлгэмүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	ОБГазраас удирдлага арга зүйгээр ханган сургууль бүрт Өсвөрийн аврагч бүлгэм байгуулан 48 хүүхэд хамрагдаж байна. ОБГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалт, болон дадлага ажилд бүлгэмийн хүүхдүүд хамрагдлаа. Бүлгэмийн хүүхдүүд Гамшгийн үед анхан шатны тусламж үзүүлэх нь сургалтыг бага насны болон бага ангийн 560 гаруй хүүхдүүдэд зохион байгууллаа.	100
2.10	Сайнцагаан, гамшгаас хамгаалах	Цаг үеийн байдлаас шалтгаалан хийгдээгүй.	-

	бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах		
2.11	“Иргэдээ сонсьё” нэгдсэн өдөрлөг арга хэмжээг өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулах	Цаг үеийн байдлаас шалтгаалан хийгдээгүй.	-
Хөтөлбөр-3. Батлан хамгаалах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх			
3.1	Дайчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодит нөхцөлийг бүрдүүлэх, тайван ба дайны үед хүн амын зайлшгүй хэрэгцээнд шаардагдах гол нэр төрлийн материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, түүнийг шинэчлэх, нөхөн сэлбэх, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах, биелэлтэнд хяналт тавих /Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.5, 17.1.7, Дайчилгааны тухай хуулийн 16 дугаар зүйл/	Төлөвлөгөөний дагуу иргэдийг томилгоожуулах, бэлэн байдлыг хангах мэдээллийг багийн засаг дарга нараар дамжуулан утсаар иргэдэд хүргүүллээ. Бүх нийтийн бэлэн байдлын үеийн гол нэрийн хүнсний нөөцийн судалгааг гарган холбогдох газарт хүргүүллээ.	70
3.2	Цэргийн бүртгэлийг зохион байгуулан явуулах хөтлөх /Батлан хамгаалах тухай хуулийн 17.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл/	Цэргийн бүртгэлийг 1-р сард зохион байгуулж, 2950 иргэн хамрагдлаа. Цэргийн насны иргэдийн 4.4 % нь 286 нь хаягандаа байхгүй, 620 иргэн бүртгэлд хамрагдаагүй байна.	70
3.3	Цэрэг татах, цэргийн албанд гэрээгээр элсүүлэх ажлыг зохион байгуулах /Батлан хамгаалах тухай хуулийн 17.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл/ Сум орон нутагтаа цэргийн насны иргэнийг эрүүлжүүлэх, боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах /Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.12/	2020 оны 2 ээлжийн цэрэг татлагыг зохион байгууллаа. Цэргийн алба хаах насны 398 иргэн хамрагдаж, 46 нь цэргийн албанд тэнцлээ. Цэрэг татлагын товчоогоор орсон иргэдийн 60 % нь өвчнөөр тэнцэхгүй байна. Сум өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт өвчнөөр хасагдсан иргэдийн нэрийг хүргүүлж,эрүүлжүүлэх үүрэг өглөө. Тус сумын хувьд цэргийн насны иргэд бүрэн дундаас дээш боловсролтой байна.	70
3.4	Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах : /Батлан хамгаалах тухай хуулийн /17.1.1/ Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шаардлагатай мэдээ, мэдээлэл	Аймгийн засаг даргын 2020 оны А/81 тоот захирамжаар тус суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн өмчит ААНэгж байгууллагад батлан хамгаалах хуулийн хэрэгжилтийг 3 өдөр цэргийн штабын бие бүрэлдэхүүнтэй шалгалт хийлээ.Нийт 35 байгууллагын 238 иргэний бичиг баримттай танилцаж ,зөрчилд хяналт хийлээ.	100

	судалгааг гаргаж өгөх /Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.9/		
3.5	Дүйцүүлэн хаалгах ажлыг зохион байгуулах /Батлан хамгаалах тухай хуулийн 17.1, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл/	Цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа 15 иргэн байна. Иргэдийг өвс боох, өвс тэжээл буулгах, малын сэг зэм устгах ажилд 5 удаа дайчиллаа.	100
3.6	Орон нутгийн хамгаалалтыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийнхээ дэд бүтцийг орон нутгийн хамгаалалтын зорилготой уялдуулан хөгжүүлэх /Орон нутгийн хамгаалалтын хуулийн 19.1.4/	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах сумын засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдож, төлөвлөгөө боловсруулан хянууллаа. Бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбогдуулан томилгооны тодотголыг хийлээ.	100
3.7	Иргэд /хүүхэд/ эх оронч үзэл, хүмүүжил, үндэсний бахархал, уламжлалыг төлөвшүүлэх, боловсрол, оюун санаа, бие бялдрыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах. Батлан хамгаалах тухай хуулийн 7.1.10/	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах уриалга зурагт хуудсуудыг бэлтгэн иргэдэд цахимаар сурталчиллаа. Сумын ИТХ-тай хамтран “Байгалиа хамгаалъя” аяны хүрээнд гэрэл зургийн уралдаан, байгаль орчинд ээлтэй байх, Хоггүй орчин амьдрах уриалга шторкыг иргэдэд сурталчиллаа. ГИЦСургууль Дээлтэй монгол өдөрлөгийг багш ажилчдын дунд цахимаар зохион байгуулж, 140000 төгрөг зарцууллаа. Сургуулиуд Угийн бичиг хөтлөх, Шагай харваа, сурын харвааны сургалтуудыг зохион байгуулж 300 суралцагч гаруй хамрагдлаа.	70
Хэрэгжилт -84.2 %			
ХОЁР. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮНС ХУДАЛДААНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД:			
4.1	Сумын нийт мал сүргийн 5%-ийг ялган тэмдэглэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулж, захиалсан ээмэгний төлбөрийг “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн дагуу малчдаас хуримтлуулж 100 хувь барагдуулах	“Уудам жаргалант” Үржлийн нэгжтэй хамтран 5574 хонины ангилалтанд хамрууллаа. Хөдөөгийн багийн иргэдийн 714 толгой малыг ээмэгжүүлж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамрууллаа. Малчдаас ээмэгний төлбөр 2474100 төгрөг хуримтлуулахаас 231500 төгрөгийг төвлөрүүлээ.	70
4.2	Сумын хэмжээнд үржилд ашиглаж байгаа бог малын хээлтүүлэгч болон бухыг 100 хувь ээмэглэж, 50-аас доошгүй хувийг удам зүйн үнэлгээний программд оруулан, захиалсан ээмэгний төлбөрийг хуулийн дагуу малчдаас хуримтлуулж 100 хувь барагдуулах	Сумын хэмжээнд үржилд ашиглаж байгаа бух-9, хуц-220, ухна-188 малыг ээмэглэж, малын бүртгэл мэдээллийн санд бүртгэж, удам зүйн үнэлгээний программд орууллаа. Малчдын отор нүүдэлтэй холбоотойгоор ээмэглэх ажил хангалтгүй удаашралтай байлаа.	40
4.3	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилтийн төслөөс хийгдэх ажлыг хамтран хэрэгжүүлэх	Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн санхүүжилттэй хамтран сумын ОНХСангаас 12.5 сая төгрөгөөр дэмжин Тэвш, Далай, Үйзэн багт мал угаалгын ванн шинээр барьж, ашиглалтанд орууллаа.	100

4.4	Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг бүрэн хангуулах сумын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	2020-2021 оны мал өвөлжилт, хаваржилт, онд оролт 98%-тай, төл бойжилт 99.2%-тай, зуншлага тааруу байсан учир гаднын аймаг, сумын нутагт 251 малчин өрх отор нүүдэлтэй байна. Сумын өвсний нөөцөд одоогийн байдлаар 75.24 тн өвс, 5.7 тн үйлдвэрийн тэжээл нөөцлөөд байна.	70																																							
4.5	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2.1.1-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх /Сайнцагаан суманд 6 /	Аймаг, орон нутгийн бодлого зорилтын хүрээнд зах зээл түүхий эд, давуу талд түшиглэн малын гаралтай дайвар бүтээгдэхүүн боловсруулах 2, арьс нэхий боловсруулах, тавилгын үйлдвэр, бүх төрлийн бүрээс оёх гэх мэт 5 жижиг үйлдвэрийг шинээр байгуулахад 147 сая төгрөгийн зээлийг олголоо.	70																																							
4.6	СХСангаас хуваарилсан зээлийн эх үүсвэрийг эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглүүлэх, олгосон зээлийн үр дүн, хэрэгжилтийг журмыг дагуу хугацаанд нь тайлагнах	Энэ онд СХС-ийн тэргүүлэх чиглэлийн дагуу <table border="1"> <thead> <tr> <th>чиглэл</th><th>Нэр төрөл</th><th>тоо</th><th>Олгосон зээлийн дүн /сая-аар/</th></tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="3">ХАА-н</td><td>Дайвар бүтээгдэхүүн</td><td>2</td><td>62</td></tr> <tr> <td>МАА-н түүхий эд</td><td>4</td><td>100</td></tr> <tr> <td>Газар тариалан</td><td>3</td><td>67</td></tr> <tr> <td rowspan="4">Хөнгөн үйлдвэр</td><td>Оёдол</td><td>3</td><td>63</td></tr> <tr> <td>Модон эдлэл</td><td>1</td><td>30</td></tr> <tr> <td>Төмөр хийц</td><td>1</td><td>20</td></tr> <tr> <td>Бэлэг дурсгал /Хэвлэл/</td><td>1</td><td>17,740</td></tr> <tr> <td>Барилга</td><td>Блок</td><td>1</td><td>17</td></tr> <tr> <td>Үйлчилгээ</td><td>Эко байгууламж</td><td>2</td><td>90</td></tr> <tr> <td colspan="2">Дүн</td><td>18</td><td>466,740</td></tr> </tbody> </table> Дээрх бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн ААН-дэд олгосон зээлийн 7 төсөл нь тэдний тогтвортой байдлыг сайжруулахад дэмжиж олгосон нь 26 ажлын байр хадгалагдаж шинээр 69 байнгын болон түр ажлын байрыг бий болгосон нь өмнөх оноос 42 оор нэмэгдсэн үр дүн гарлаа.	чиглэл	Нэр төрөл	тоо	Олгосон зээлийн дүн /сая-аар/	ХАА-н	Дайвар бүтээгдэхүүн	2	62	МАА-н түүхий эд	4	100	Газар тариалан	3	67	Хөнгөн үйлдвэр	Оёдол	3	63	Модон эдлэл	1	30	Төмөр хийц	1	20	Бэлэг дурсгал /Хэвлэл/	1	17,740	Барилга	Блок	1	17	Үйлчилгээ	Эко байгууламж	2	90	Дүн		18	466,740	100
чиглэл	Нэр төрөл	тоо	Олгосон зээлийн дүн /сая-аар/																																							
ХАА-н	Дайвар бүтээгдэхүүн	2	62																																							
	МАА-н түүхий эд	4	100																																							
	Газар тариалан	3	67																																							
Хөнгөн үйлдвэр	Оёдол	3	63																																							
	Модон эдлэл	1	30																																							
	Төмөр хийц	1	20																																							
	Бэлэг дурсгал /Хэвлэл/	1	17,740																																							
Барилга	Блок	1	17																																							
Үйлчилгээ	Эко байгууламж	2	90																																							
Дүн		18	466,740																																							
4.7	Зориулалтын бус хүнсний савны хэрэглээгүй сум хөдөлгөөнийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх /Зохист судалгаа хийгдсэн байх, Олон нийт мэдлэг мэдээллээр хангагдсан байх, хуванцар савны хэрэглээг 70-аас доошгүй хувиар бууруулсан байх/	Зориулалтын бус хуванцар савны хэрэглээг хориглох тухай 2020 оны 01 сарын 20 ны өдрийн А/14 тоот сумын Засаг даргын захирамж гаргалаа. Захирамжийг 9 багийн Засаг дарга, нийтийн хоолны 22 газар, сургууль, цэцэрлэг, Тогтох мандал хүнсний захад хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажиллах талаар үүрэг өглөө. Зориулалтын бус хуванцар савны уриалга, зөвлөмжийг 18 худаг дээр байршуулж, 383 иргэнд гарын авлага тараалаа. Тус сумын 9 багийн 4734 өрхөөс 1280 өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон бөгөөд үлдсэн 3454 өрхөөс Зориулалтын эко сав болон төмөр саваар ус зөөдөг 1607 өрх, зориулалтын бус хуванцар саваар ус зөөдөг 1847 өрх байна. Ундны усаа зориулалтын эко саванд хадгалдаг 910 өрх, зориулалтын бус хуванцар саванд хадгалдаг 883 өрх байна. Үүнээс харахад нийт өрхийн 47,3 % нь зориулалтын эко саваар ус зөөдөг, 53,4% нь зориулалтын эко саванд ундны усаа хадгалж байна. Эко сав-Элэг бүтэн амьдрал уриалгыг цахимаар дэвшүүлж иргэдийг уриаллаа. Номгон- рашаан ХХК, Өнөмөнх	40																																							

		хайрхан ХХК, 1998, Цоглог ертөнц ХХК худалдааны төвүүдэд Эко сав худалдаалж бидэнтэй хамтран ажиллах талаар засаг даргын албан тоотыг хүргүүллээ.Тогтох мандал ХХК-ийн хүнсний захад Зориулалтын бус хуванцар саванд цагаан идээ худалдаалж байсныг зориулалтын саваар солиуллаа.	
1.8	Сум орон нутгийн хэмжээнд хүн амын стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Хүн амын стратегийн 12 төрлийн хүнсний бүтээгдэхүүний нөөцөөр хангах гэрээт үйлдвэр, худалдааны төвүүдээс 7 хоног бүр 11 сарын 15-аас өдөр бүр хүнсний нөөцийн судалгааг авч ХХААГазар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газарт хүргүүллээ. 2020.12.01 ны байдлаар гурил 23.1 тонн, хуурай сүү 0.8 тонн, төмс 35.6 тонн, хүнсний ногоо 7.0 тонн, өндөг 0.480 тонн, гурилан бүтээгдэхүүн 3,7тонн, будаа 10,4 тонн, ургамалын тос 1,8 тонн, давс 3,5 тонн, элсэн чихэр 5,0 тонн, Цэвэр ус 7,63 тонн байна.	70
1.9	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбарт шинээр батлагдсан эрхзүйн баримт бичгийг сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах	Сумын ЗДТГазар , Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран Монгол улсын стандарт-Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946-2019,Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ MNS 5021-2019 стандартуудаар сургалт зохион байгууллаа. Сургалтанд нийт 31 аж ахуй нэгжүүд хамрагдлаа. Мөн цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн Ц.Батцэцэг “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх” тухай хуулиар мэдээлэл хүргэлээ. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч ААН-ын цаг үеийн шуурхай мэдээлэлд хамруулах зарыг хүргэж зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 30 ААН, иргэн оролцож тэдэнд 2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтын ажил,СХС-ийн 2020 оны тэргүүлэх чиглэл, зээлийн дээд хэмжээ,шалгаруулах товын талаар, байгаль орчны үнэлгээ хийлгэх, менежментийн төлөвлөгөө батлуулах, Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мэргэжлийн хяналтын зөвлөмжийг танилцуулах, COVID 19-с урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар тус тус шуурхай мэдээллийг хүргэлээ.	70
1.10	Төмс 7 га, хүнсний ногоо 4 га, малын тэжээл 2 га, жимс жимсгэнэ 2 га-д тариалалт хийж төмс хүнсний ногоо 150 тн, малын тэжээл 4 тн, жимс жимсгэнэ 1 тн-ыг хураан авах	Энэ онд 5.7 га-д төмс тариалж 72,4 тн , 4,3 га-д 19 нэр төрлийн хүнсний ногоог тариалж 54,9 тн, 14,1 га талбайд тариалагдсан жимс, жимсгэний бутнаас 0,9 тн жимс жимсгэнэ нийт 128,2 тн ургацыг хураан авсан нь өмнөх оноос 18,6 тн-оор нэмэгдсэн үр дүн гарч өрх гэрийн хэрэгцээнд болон зах зээлд борлуулж хүн амыг шинэ ургацын ногоогоор хангасан байна. 349 100 төгрөгийн 4 төрлийн үрийг төмс хүнсний ногооны 38 тариаланчид олгож Тариалан эрхлэгч 3 иргэнийг СХС-ийн хөнгөлөлттэй зээлд хамруулж 67 сая төгрөгөөр дэмжлээ.	100
1.11	Мал, амьтны өвчлөлийн дуудлага бүрт малын эмч нарыг хүрч ажиллуулан тэдгээрээс эмгэг материалын сорьц авахуулж аймгийн мал эмнэлгийн лабораторид тухай бүр хүргүүлж шинжлүүлэн дүн, дүгнэлтийг гаргуулан тэмцэх,	Сумын хэмжээнд 51 удаагийн мал, амьтны өвчлөлийн дуудлагад МЭҮН-ийн эмч нар үзлэг, эмчилгээ, оношлогоо хийлээ. 25 эмгэгт материалын сорьц, 18 ийлдэс бүгд 33 дээжийг авч аймгийн Мал эмнэлгийн лабораторид тухай бүр хүргүүлж шинжлүүлэн онош баталгаажуулан дүн, дүгнэлт гаргуулан тэмцэх, сэргийлэх арга хэмжээг хийлээ. Үүнээс: Адууны нийлүүлгийн өвчин 2 оношлогдож эмчилгээнд хамруулж, мал, амьтны халдварт галзуу өвчин 2 оношлогдож, сумын Засаг даргын захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоож, голомтын бүсэд байгаа 3 айлын 105	100

	сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	үхрийг дархлаажуулалтанд хамрууллаа.	
1.12	Дуудлагын дагуу анхны онош үйл ажиллагааны тээвэр шатахууны зардал, халдварт өвчин гарсан үед халдваргүйтгэлийн бэлдмэлийн үнийг шийдвэрлэж ажиллах.	Халдварт өвчний 2 удаагийн дуудлаганд шатахууны зардал, халдваргүйтгэлийн эм бэлдмэлийн үнийг шийдвэрлэлээ.	100
1.13	Малын эмч мэргэжлээр суралцах хүүхдийг дэмжих, боловсон хүчний нөөц нэмэгдүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж /МЭҮН/ эрхлэх малын эмч нарт дэмжлэг үзүүлэх	Малын эмч болох сонирхолтой ЕБС-ийн 12 дугаар анги төгссөн 3 хүүхдийн тодорхойлолтыг зохих газар нь уламжилснаар Мал эмнэлгийн сургуулийн 1-р курст суралцаж байна. Малын эмч нарт дэмжлэг үзүүлж „Далай, Тэвш, Үйзэн багт шинээр мал угаалгын банныг шинээр бариуллаа.	100
1.14	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн ажлын байрыг сумын төвд нийтийн үйлчилгээний газар, орон сууц, гэр хорооллоос зайдуу, хүн малын халдварт өвчин тархахаас хамгаалагдсан бүсэд газар олголт хийж байршуулах. Тайлбар: МХЕГазраас 2019 онд хийсэн шалгалтаар өгсөн албан шаардлагад тусгасан заалт	Тус суманд МЭҮН үйл ажиллагаа явуулдаг 3 нэгж байна. Мал эмнэлгийн 1 нэгж гэр хороололд байршилтай, 2 нь шинээр ажлын байр барих газраа орон сууц, үйлчилгээний газар, гэр хорооллоос зайдуу байршилтайгаар шинээр Мал эмнэлгийн байр барьж эхэллээ.	100
1.15	Мал эмнэлгийн цахим системийн хэрэгжилтийг хангуулж, малын эмчийг стандартын дагуу тогтвор суурьшилтай ажиллахад шаардлага тавьж ажиллах	Мал эмнэлгийн үйл ажиллагаа нь цахим системд шилжлээ. Мал эмнэлгийн үйл ажиллагааны Стандартын шаардлагыг хангуулахаар 3 мал эмнэлгийн нэгжийн бэлэн байдлын үзлэгийг хяналтын хуудсаар үнэлж, гарсан зөрчилд нь хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг тооцлоо.	100
1.16	Тухайн сумын мал, амьтанд илэрдэг халдварт, халдваргүй, шимэгчтэх өвчний дуудлага бүрт Мал эмнэлгийн тасаг /МЭТ/, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж /МЭҮН/ хүрч ажиллах, хагас жил, жилийн эцсээр тайлагнах	Мал, амьтны өвчлөлийн 51 удаагийн дуудлагын дагуу МЭҮН-ийн эмч нар үзлэг, эмчилгээ, оношлогоо хийж ажиллаж байна. Энэ тухай сар бүр гаргадаг гүйцэтгэлийн тайланд тайлагналаа.	100
1.17	Мал, амьтны өвчлөл бүртгэгдсэн тохиолдол бүрийг сумын газрын зурагт тэмдэглэх /халдварт, шимэгчтэх өвчний зураглал хийсэн байна/	Малын гоц халдварт болон халдваргүй, шимэгчтэх өвчний голомтын 1998 оноос хойшхи 21 жилийн судалгааг гаргаж, газрын координатыг тэмдэглэж, цахим системд байршууллаа. Судалгаанд нийт 1029 малчин, мал бүхий иргэд хамрагдаж, сүүлийн 21 жилийн хугацаанд давхардсан тоогоор 330 голомтонд гарсан өвчлөлийн судалгааг нэгтгэлээ. Мал, амьтны өвчлөл бүртгэгдсэн тохиолдол бүрийг сумын газрын зурагт өвчний төрөл бүрээр нь өнгөөр ялгаж тэмдэглэгээ хийлээ.	100

1.18	Тухайн суманд хэрэгжүүлэх мал, амьтны дархлаажуулалтын ажлыг графикт хугацаанд захирамж, зарлан мэдээлэх товыг гаргаж хэрэгжүүлэх	Төлөвлөгөөт 5 төрөл, захиалгат 1 төрөл нийт 6 төрлийн дархлаажуулалтыг графикт хугацаанд нь эхлүүлэх тухай Сумын Засаг даргын захирамжаар багийн Засаг дарга нараар товыг зарлуулан цаг хугацаанд нь гүйцэтгэлээ.	100
1.19	Тухайн суманд хэрэгжүүлэх мал, амьтны өвчний халдвар илрүүлэх тандалтын ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулахад анхаарах хэрэгжилтийг хангуулж ажиллах	Үхрийн цээж, ямааны годрон өвчний тандалтын ажлын хүрээнд сумын төвийн мал нядалгааны цэгт нядлагдаж байгаа ямаа, үхрээс түүврийн аргаар дээж цуглуулж аймгийн Мал эмнэлгийн лабораторит хүлээлгэн өгөө. Нийт 25 ямаа, 10 үхрийн уушгинаас дээж цуглуулж шинжлүүлээ.	100
1.20	Бруцеллөз өвчний байгалийн халдвар илрүүлэх тандалтанд сумын нийт бух, буур, хуц, ухныг ялган суурилж, ээмэгжүүлэн шинжилгээнд 100% хамруулах	Бруцеллөзын шинжилгээнд 1 буур, 16 бух, 275 хуц, 150 ухна нийт 443 хээлтүүлэгч хамрагдсанаас 7 хуц, 3 ухна эерэг /өвчтэй/ гарсан тул “Мал, амьтны бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар-ын” дагуу арга хэмжээ авлаа.	70
1.21	Малын эрүүл мэндийн үзлэг, угаалга, боловсруулалт, сэг зэм устгал, хороо хашааны халдваргүйцтэгийг сумын хэмжээнд оновчтой зохион байгуулах	Мал сүргийг халдварт болон гоц халдварт, халдваргүй, шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт тэмээ-139, адуу-852, үхэр-15935, хонь-262390, ямаа-251787 бүгд 531103 малыг хамруулж, төлөвлөгөөг 120.0% гүйцэтгэлээ. Угаалганд үхэр-4164, хонь-193942, ямаа-205266 бүгд 403372 мал хамруулж, 104,67% байна. Хөдөөгийн 4 багт болон аймгийн төв орчим, засмал зам дагуу 569 км явж, нийт 821 үхсэн малын сэг зэмийг цуглуулж, аймгийн төвлөрсөн хогийн цэгт булж ариутгал халдваргүйтгэл, 32 өвөлжөө, 18 уст цэг, бэлчээрийн 11900 мкв талбайг ариутгалаа.	100

2.Байгаль орчин, аялал жуулчлал, ашигт малтмал, уул уурхайн бодлого зохицуулалтын хүрээнд

2.1	Бүх нийтээр мод тарих аяныг зохион байгуулж, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг өргөтгөх, засмал замын дагуу байгууллага, ААН-эгж, иргэдээр мод тариулах / 1 эс доошгүй га-д 500 аас доошгүй мод тарих /	Бүх нийтээр мод тарих аян, "Ногоон Мандалговь" дэд хөтөлбөр болон Албан байгууллага, иргэд 15600 цэцэг, 4786ш мод суулган арчилж хамгаалалтыг хийлээ. Ногоон байгууламж 3 хувиар нэмэгдлээ.	100
2.2	Ус хангамжийн эх үүсвэрт /сумын төвийн худаг бүр дээр/ эрүүл ахуйн, хамгаалалтын бүс тогтоолгох	Сумын ИТХурлын 2020 оны 09 сарын 18-ны өдрийн 21 дугаар тогтоолоор Олгойн говийн гүний 3 худаг, сумын төвд гүний 3 худаг, насос станц 3, ус түгээх байр 18 , нийт 27 газрыг хамгаалалтад авсан байна.	100
2.3	Аймаг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газар нутгийн холбогдох шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах	Аймаг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газрын санал гараагүй.	-
2.4	“Хоггүй цэвэрхэн монгол”, “Цэвэрхэн наадацгаая” аяныг зохион байгуулан	Сумын Засаг даргын А/101 захирамжийн дагуу нийтийн угаалга, цэвэрлэгээг зохион байгууллаа. Цэвэрлэгээнд 58 байгууллагын 1056 албан хаагч 2500 га талбайд	100

	бүх нийтийн цэвэрлэгээг тогтмолжуулах, хог хаягдлын нэгдсэн цэгийн талбайг шууж багасгах	148м ³ (49.3тн) хог цэвэрлэж, байгууллагын орчин,явган замд угаалга хийлээ. Хог хаягдлын нэгдсэн цэгийн хог тархсан талбай нэмэгдэхээс сэргийлж 4 км урттай хамгаалалтын зурвасыг хийлээ. Ингэснээр нийт 52 га талбайд нэмж хог хаягдал хаях явдал багаслаа. БОАЖЯ-ны Агаар орчныг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр хог хаягдлын нэгдсэн цэгт хог хаягдал хүлээж авах 80*45*5 /1800м ³ / харьцаатай нүх ухах ажлыг “Миний хүлэг” ХХКомпани хийж гүйцэтгэлээ.	
2.5	Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогийг харуулсан “Хотод ойрхон говь” эвент арга хэмжээг зохион байгуулж, гадаад, дотоод жуулчдын тоог нэмэгдүүлэх	Өндөржүүлсэн бэлэн байдлаас болж хийгдээгүй.-	-
2.6	Тогтвортой эко аялал жуулчлал хөгжүүлэх, нутгийн иргэдийг аялал жуулчлалтай холбож орлогын эх үүсвэрээр хангах ажлыг зохион байгуулах	Өндөржүүлсэн бэлэн байдлаас болж хийгдээгүй.-	-
2.7	Ашигт малтмал, уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд тавих хяналт шалгалтыг зохион байгуулж, хариуцлагыг нэмэгдүүлэх	Тэвшийн говийн нүүрсний уурхайн 2019 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг БОАЖГазар, МХГазартай хамтран явуулахад бага эрсдэлтэй үнэлэгдлээ. Менежментийн төлөвлөгөөг 82 хувьтай дүгнэлээ.	70
2.8	Ашигт малтмал хулгайгаар олборлох асуудлыг таслан зогсоох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Үйзэн багийн нутаг Төгрөг гэх газар хууль бус хайлуур жонш олборлолт хийж байсан 2 удаагийн мэдээлэлд 3 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 9 иргэнд 1.800.000 төгрөгний торгууль тавьж, хууль бус үйлдлийг зогсоолоо.	100
2.9	Нөхөн сэргээлт нэрээр хууль бусаар ашигт малтмал олборлох асуудлыг ил, далд байдлаар тусгасан аливаа гэрээ хэлцэл байгуулахыг таслан зогсоож, уул уурхайн олборлолт, бичил уурхайн эвдэрсэн газар болон эзэнгүй орхигдсон газрын нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэх, хяналт тавих нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх	Сумын хэмжээнд ашигт малтмал олборлох асуудлыг ил, далд байдлаар тусгасан аливаа гэрээ, бичил уурхайн эвдэрсэн газар болон эзэнгүй орхигдсон газар байхгүй болно.	100
3.Дэд бүтэц хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, өмчийн бодлого зохицуулалтын хүрээнд			
3.1	Газар усны нэрийн тодруулгын ажлыг зохион байгуулах	Сумын газар зүйн нэрийг 4 эх үүсвэрээс 6 төрлийн мэдээллийг бүрдүүлж нийтдээ давхардсан тоогоор 2370 нэрийг цуглууллаа. УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолд сумын хэмжээнд газар зүйн 610 нэр багтсан байна. Газар зүйн нэрийн	100

		тодруулалтын хээрийн судалгаагаар 150 газар зүйн нэрт тодруулалт хийж, нийт 86 малчид, иргэдтэй уулзаж, тодруулан газар зүйн нэрийг гарын үсэг зуруулан баталгаажууллаа. Сумын хэмжээнд 734 нэр бүхий газар зүйн нэрийн мэдээлийн санг үүсгэлээ.	
3.2	Техникийн хяналтын үзлэгт сумынхаа албан байгууллага, иргэдийн болон нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	Техник хяналтын үзлэгийн зарыг цахимд байршуулан харьяа байгууллагын удирдлагууд болон багийн засаг дарга нарт мэдээллээ. Техникийн үзлэгт албан байгууллагуудын авто машин бүрэн хамрагдлаа. Сайнцагаан сумын хэмжээнд нийт 4528 машин үзлэгт орсон байна.	70
3.3.	Орон сууцны оршин суугчдын хариуцлагыг өндөржүүлэх, орон сууцны хонгил инженерийн шугам сүлжээний ашиглалтыг хариуцах нэгж байгуулан эзэнтэй болгох	СӨХ байгуулах саналыг иргэдээс авах цуглааныг 3 удаа зохион байгууллаа. Иргэдийн цугларалт хангалтгүй байсан тул шийдэлд хүрээгүй.	40
3.4	2019-2020 болон 2020-2021 оны ХАА-н болон төв суурин газрын өвөлжилтийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг эрчимжүүлэх	Энэ оны мал онд оролт 98.%, төл бойжилт 99.2%-тай, гадны 8 аймаг, өөрийн 13 сумын нутагт 216 малчин өрх, 143 мянган толгой мал оторлож байна.Сумын нөөцөд 43.24 тн өвс, 5.7 тн тэжээл байна. Малчид өвс 170 тн, тэжээл 65 тн, гар тэжээл 7.тн, хужир 30 тн-ыг бэлтгэлээ. Орон нутгийн бизнес эрхлэгчид малын өвс, үйлдвэрийн хивэг, хорголжин, ногоон тэжээл, овъёос, буудайг зах зээлээс авч худалдаалж байна. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд ажлын хэсэг халаалтын зуухнуудын бэлэн байдал засвар үйлчилгээтэй танилцаж, зөвлөмж өглөө. Хотын дулаанаар үйлчлэх байгууллага, ААНэгжүүд төлөвлөгөөт засваруудыг хийлээ.	100
3.5	Улсын болон ОНХСан, гадаадын төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа ажлыг графикайн дагуу эрчимжүүлэх	БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар 4, 5-р цэцэрлэгийн барилгын дээврийг 60 сая төгрөгийн өртөгтэй засварын ажлыг “Бейс буйлдинг”, “Дөл” ХХК-иуд, ГИЦСургуулийн спорт тоглоомын талбайн тохижилтыг улсын төсвийн 178,19 сая төгрөгөөр “Мандал шилтгээн” ХХК гүйцэтгэлээ. Аймгийн төвийн 2,8 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлыг улсын төсвийн 2,176.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Дэвжих-Эрдэнэ” ХХКомпани гүйцэтгэж байна. Аймгийн ОНХСангийн 165,966,186 төгрөгний хөрөнгөөр “Сүлд оюу хайрхан” ХХКомпани 5, 12-р байрны фасад, явган замын ажил, төвийн 9, 13, 5, 12 дугаар байрын гадна тохижилт, тоглоомын талбайн тохижилтыг “Мандал шилтгээн” ХХК 202,828,688 төгрөгөөр гүйцэтгэлээ. Ингэснээр 4 байрны 144 айлын 576 орчим оршин суугчдын амьдрах таатай орчин бүрдлээ. Сумын ОНХСангийн хөрөнгөөр хог хаягдлын нэгдсэн цэгийг хашаажуулах ажлыг “Өгөөмөр бурхант” ХХКомпани 800 метрийн урттай 2 метрийн өндөртэй торон	100

		хашааг барилаа.	
3.6	Орон нутгийн хөгжлийн индекс /http://idi.nda.gov.mn/-ын цахим системд 2019 оны сумын хөгжлийн индексийн үзүүлэлтийн мэдээллийг 2020 оны 2 сарын 15-ны дотор шинэчилж оруулах	Орон нутгийн хөгжлийн индексийн программд сумын ерөнхий үзүүлэлт 5 сургууль, 8 цэцэрлэг, сумын ЭМТөв, өрхийн эмнэлэг, зочид буудлууд, сумын дэд бүтэц зэрэг нийгэм эдийн засгийн 30 төрлийн мэдээллийг хугацаанд нь оруулж баталгаажууллаа.	100
3.7	Сангийн сайдын 228 тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2-т заасны дагуу 2 сарын 1-ны дотор Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст 2019 оны ОНХС-н тайланг маягтын дагуу ирүүлэх	Сангийн сайдын 228 тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.2-т заасны дагуу 2019 оны ОНХС-н тайланг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүллээ.	100
3.8	Сумын танилцуулга /http://sector.gov.mn/-г 2020 оны 3 сарын 20-ны дотор шинэчлэх	Сумын ИТХ-ын 2019 оны 15 тоот тогтоолоор нийт 11 бараа, ажил үйлчилгээнд 167,655.6 мянган төгрөг зарцуулахаар батлагдлаа. ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил үйлчилгээний холбогдох бүх мэдээллийг Сангийн яамны нэгдсэн сүлжээнд бүртгэн 11 бараа ажил үйлчилгээний холбогдох цогц мэдээллийг цахим сүлжээнд мэдээллээ.	100
3.9	Засаг даргад эрх шилжүүлсэн арга хэмжээний явцын мэдээллийг сар бүрийн 2-ны дотор Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст тайлагнах	Аймгийн засаг даргаас аймгийн ОНХСан болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийх 5 ажил арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг сумын засаг даргад шилжүүлсэнээр нээлттэй тендер шалгаруулалт 1, харьцуулалтын аргаар 2 тендерийг хуулийн дагуу зохион байгуулж, ажлын гүйцэтгэл 100 хувьтай хэрэгжлээ. “Бункер өргөгч машин”, “Хогийн бункер нийлүүлэх” ажлуудын тендер шалгаруулалт цаг үеийн байдлаас шалтгаалан явагдаагүй байна.	70

Хэрэгжилт 87.5 %

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭ

Хөтөлбөр 1 Хууль тогтоомжид нийцсэн бодлого, шийдвэр баталж, хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчилж, хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулна

1.1	Иргэд, олон нийтийн эрх ашгийг хөндсөн /Захиргааны хэм хэмжээ тогтоосон / шийдвэр батлах, боловсруулахдаа Захиргааны ерөнхий хуулинд нийцүүлэн, төслийн шатанд иргэдээ сонсоха, саналыг нь авах,хэлэлцүүлэх зэргээр тэдний оролцоог хангах үйл ажиллагааг тогтмолжуулж, ХЗДХийн яаманд	Захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гараагүй болно.	-
-----	--	---	---

	хянуулах, бүртгүүлнэ /Захиргааны ерөнхий хуулийн 26,27,29,59,60,61,62,64 дүгээр зүйл/		
1.2	Сумын Засаг даргын захирамж, шийдвэрийг батлагдсан хуваарийн дагуу Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулж, зөвлөмжийг хэрэгжүүлнэ	Сумын Засаг даргын эхний 3 улиралд гаргасан захирамжийг хянуулан зөвлөмжийг хэрэгжүүллээ. Захирамжийн зөрчлийг арилган хариуг албан бичгээр хүргүүллээ.	100
1.3	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд сумын “Эрх зүйн хөтөч” багаас Насан туршийн боловсролын нэгжтэй хамтран хүргүүлсэн хууль тогтоомжийн жагсаалтын дагуу эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна	Сумын ЗДТГазар эрх зүйн хөтчөөр 5 албан хаагч ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар видео хичээлийг ЗДТГазар пейж хуудсанд байршуулан 593 иргэн үзэж, 38 иргэн шэйр хийлээ. 253 өрхөөр айлчилж, 3 хууль, 5 зөвлөмжийг насанд хүрэгчид 388, бага насны 83 хүүхэд, өсвөр насны 67 сурагчдад хүргэлээ. Mandal school 2015 нээлттэй групп хуулийг 7 хоног бүр сурталчилан нийт 2100 гишүүд танилцлаа. Covid-19 өвчлөлийн талаар иргэдэд багуудын пэйж хуудас, Сайнцагаан ЗДТГазрын пэйж хуудас болон 180 гарын авлага хэвлэж иргэдэд тараалаа.	70
1.4	Эрх зүйн хөтөчийн ажиллах журмын дагуу бэлтгэгдсэн “Эрх зүйн хөтөч” бүртэй гэрээ байгуулан ажиллуулж удирдлага, зохион байгуулалтаар ханган, дэмжлэг үзүүлж батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу ажлыг нь дүгнэн, эрчимжүүлж тайлагнана.	Сумын эрх зүйн хөтөч 4 албан хаагчтай гэрээ байгшуулан ажиллалаа. Журмын дагуу зохион байгуулсан ажлыг шалгуурын дагуу үнэллээ. Үнэлгээний дундаж 70 хувьтай байна.	70
1.5	“Малчин танд” иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан гарын авлагыг багийн Засаг дарга нараар дамжуулан малчин өрх бүрээр судлуулж, тайлагнана	Малчдад зориулсан “Малчин та” хуулийн гарын авлагыг 9 багийн хэмжээнд 119 малчин өрхийн 302 иргэнээр аялуулж, шаардлагатай мэдээллийг хүргэлээ. Нийт 9 багийн нийт 447 малчинд танилцууллаа.	70
1.6	Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, төрийн албан хаагчдын өдөр тутмын хэрэглээнд зориулан бэлтгэсэн шторк, богино хэмжээний кино болон бусад цахим сурталчилгаа мэдээлэл /Авлигаас урьдчилан сэргийлэх ХАСХОМ харандаа, Ашиг сонирхол харандаа,ХАСУМ шторк гэх мэт/-ийг орон нутгийн мэдээллийн хэрэгслээр болон цахим хэлбэрээр иргэд, олон	Сумын цахим хуудсаар Авилгаас урьдчилан сэргийлэх 14 шторк, 5 посторыг иргэдэд сурталчилж, 55 хуудас гарын авлагыг “Иргэн танаа” буланд байршуулан танилцах боломжоор хангалаа. Албан хаагчдад мэдээллийг байгууллагын цуглаанд ,шаардлагатай тохиолдолд тогтмол явууллаа.	100

	нийтэд сурталчилан таниулна		
1.7	“Олон Улсын Хүний эрхийн өдөр”-ийг угтан иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр иргэд, олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа зохион байгуулна	Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан “Шинэ үеийн залуус шударга ёсыг юу гэж ойлгодог вэ?” хэлэлцүүлгийг мэргэжилтнүүдийн дунд зохион байгууллаа. Өнөөгийн нийгмийн залуус шударга ёсыг иргэний хуулийн мэдлэг, ёс зүй, хандлага,хувь хүний өөрчлөлт,оролцоо гэдгээр тодорхойлж байна. Залуу албан хаагчид энэ сэдвээр эссэ бичиж шалгарууллаа.	70
Хөтөлбөр 2 Төрийн албанд шударга ёс ил тод байдлыг бэхжүүлж, авилга, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг хэрэгжүүлнэ			
2.1	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн II шатны буюу 2020 оны үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөн баталж, хэрэгжилтийг ханган авилга, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана	Төрийн албан хаагчид,харьяа байгууллагын удирдлагуудад Авилгатай тэмцэх газрын зөвлөмжийг танилцууллаа. Зөвлөмжийн дагуу засаг даргын нөөцийн зардлаас хөрөнгө гаргахдаа засаг даргын зөвлөлийн гишүүдээр хэлэлцүүлж,захирамж гаргаж хэвшлээ. “Би авилга өгөхгүй авахгүй” арга хэмжээг зохион байгуулж, энгэрийн тэмдгийг мэргэжилтнүүдэд олголоо. Авлига,ашиг сонирхолтой холбоотой гомдол, асуудал гараагүй.	100
2.2	Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээллийг нийт ажилтан, албан хаагч, иргэдэд тогтмол хүргэж, зайлшгүй шаардлагатай сургалтын мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулна	Сумын цахим хуудсаар Авилгаас урьдчилан сэргийлэх 14 шторк, 5 посторыг иргэдэд сурталчилж, 55 хуудас гарын авлагыг “Иргэн танаа” буланд байршуулан танилцах боломжоор хангалаа. Албан хаагчдад мэдээллийг байгууллагын цуглаанд ,шаардлагатай тохиолдолд тогтмол явууллаа.	70
2.3	Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ хянуулж, шинээр томилогдсон буюу их хэмжээний өөрчлөлтийг 30 хоногт багтаан авч баталгаажуулах, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүрт нь гаргуулах, дээрх бүртгэлүүдийг ХАСХОМ программын ЭБАТ цэсэнд бүрэн хөтөлж хэвшинэ	Энэ онд ЕБСургуулийн сургалтын менежер 4, сургуулийн захирал 1,цэцэрлэгийн эрхлэгч 1,багийн засаг дарга 5 нийт 11 албан тушаалтны ХАСУМ-ийг цахимаар хянуулан, хуулийн хугацаанд ХАСХОМ-ийг гаргууллаа. Ажлын байрны томилгооны зөрчилгүй ажиллаж, ХАСХОМ гаргагч нар 2019 оны мэдүүлгээ хуулийн хугацаанд цахимаар гаргалаа.	100
2.4	Авлигатай тэмцэх газрын даргын 2016 оны А/54 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ны үйл ажиллагааг үнэлж, дүгнэнэ	Сумын ЭБАТушаалтны 2019 оны үнэлгээ 93 оноотой дүгнэгдлээ.	100

Хөтөлбөр 3 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ			
3.1	Сумын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл болон гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн хэсэг, хэсгийн төлөөлөгчийн зохиож буй ажлын талаарх сонсгол, мэдээллийг сумын Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, зохих шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд үүрэг даалгавар өгч биелэлт үр дүнг тооцож эрчимжүүлнэ	Цагдаагийн хэсгийн төлөөлөгч шинэчлэгдэн үүрэг чиглэлийг тухай бүр өгч байна. Ажлын мэдээллийг сар бүр авч холбогдох албан тушаалтанд танилцууллаа.	40
3.2	“Архидалтгүй аймаг –Дундговь” хөтөлбөр /2018-2020/-ийг орон нутгийн онцлоготой уялдуулан хэрэгжүүлж, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр иргэд залуучуудад чиглэсэн нөлөөллийн ажлыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах, аймгийн хэмжээний нэгдсэн ажил, арга хэмжээнд иргэд, залуучуудыг нэгдсэн зохион байгуулалттай оролцуулж дэмжлэг үзүүлнэ.	“Сархадгүй Сайнцагаан” хэсэгчилсэн арга хэмжээг иргэдэд танилцуулга хуудас болон цахим хэлбэрээр хийлээ. Сумын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 32 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	70
3.3	ГХЗУСэргийлэх ажилд иргэд, байгууллага, ААНэгжийг татан оролцуулах, зохих үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх замаар тэдэнтэй хамтран байгууллага, аж ахуй нэгжийн гадна орчин, нийтийн эзэмшлийн орон сууц, машины зогсоол, гэр хорооллын гудамж талбайг камержуулах, гэрэлтүүлэг, зогсоолыг нэмэгдүүлж гэмт хэргээс, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлнэ	Харъяа боловсролын байгууллагууд гадна дотно талдаа бүрэн камертай боллоо.Хотын төвийн гэрэлтүүлгийг сайжруулж,гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, Буян нэмэхийн өргөн чөлөөний гудамжны авто замын гэрэлтүүлгийн шонд 53 ш нэмэлт чимэглэл гэрэлтүүлэг суурилуулах ажлыг “Мосума корпораци” ХХК –тай хамтран сумын ОНХС-ын 9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.	70

3.4	Суманд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг орон байр, тээвэр, холбооны хэрэгсэл согтуурал хэмжих багажаар хангах, шаардлагатай урсгал зардал /халаалт, цахилгаан, засвар үйлчилгээ, шатахууны гэмт мэт/-ыг шийдвэрлэх түүний гэр бүлийн гишүүнийг ажлын байраар хангахад тус тус дэмжлэг үзүүлнэ. /Цагдаагийн албан тухай хууль 94 дүгээр зүйл/	Тус сумын ЗДТГазраас цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжин,сүүлийн 2 жилд 2 авто машин,согтуурал хэмжих багаж олголоо. Цагдаагийн төлөөлөгчид 80 л бензины дэмжлэг үзүүллээ.	70
3.5	Сумын хэмжээнд онцгой хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй иргэд, хүүхдүүд, гэр орондоо байнга түгшүүр төрүүлдэг этгээдүүдийн судалгааг шинэчилж, холбогдох хууль тогтоомжид заасан үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих, уг зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа бусад үйл ажиллагааг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулна	Цагдаагийн газар, Оюуны гэгээ ТББ, сумын ИТХурал хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа”, цахим аяныг “Харуусал биш хайр өвлүүлье” уриатай зохион байгууллаа. Аяны хүрээнд 12 постер, 19 видео мэдээллийг цахимд байршуулж, хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд 37 өрх, гэр бүлийн хүчирхийлэлтэй 14 айл өрхөөр айлчилж, нөхцөл байдалтай танилцаж зөвлөгөө зөвлөмж өглөө. 2020 онд цагдаагийн байгууллагаар шалгагдсан гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 20 иргэний гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, нийгмийн ажлын үйлчилгээг хамтарсан багаар ажиллан, гэр бүлд хууль эрх зүйн зөвлөгөө, зөвлөмж, хүчирхийлэл үйлдэгчдээс амлалт авлаа. Өмнөх онтой харьцуулахад 9 кейс буюу 45%-иар өссөн байна.	70
Хөтөлбөр 4 Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, стандартыг бүрэн мөрдүүлнэ			
4.1	Сум, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ORG-AMS программын хангамжийг нэмэгдүүлж, онлайн системд холбох ажлыг зохион байгуулж, программын ашиглалт, хяналтыг сайжруулна	Бүх байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ORG-AMS программыг баазаар суулгалаа. Программыг үргэлжүүлэн ашиглаж байна.	100
4.2	Цахим санд оруулсан мэдээллийг зөөврийн хард диск болон CD дискэнд буулгаж хамгаалалтын болон ашиглалтын цахим хувьтай болгох ажлыг үргэлжүүлэн гүйцэтгэнэ	Захирамжлалын баримт бичгийг сканердаж CD-д буулган бүртгэл хөтөлж, цахим хувьтай болголоо.	70
4.3	Архивын Ерөнхий газраас 2020 онд зохион байгуулах сургалтанд сум, байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтанд захиалгын дагуу суралцуулна	Архив,бичиг хэргийн ажилтан шинээр томилогдсон учраас сургалтанд хамруулах захиалгыг хүргүүллээ.Цаашид мэргэшүүлэх шаардлагатай байна.	100

4.4	Төрийн архивын баримтын нөхцөл бүрдүүлэлтийг холбогдох заавар, төлөвлөгөө графикийн дагуу хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна	Аймгийн төрийн архивт нөхөн бүрдүүлэлтээр тушаах 2009-2012 оны мал тооллогын “А” дансны 17 баримт, төрийн архивт нөхөн бүрдүүлэлтийн график хуваарийн дагуу 2009-2011 оны 91 баримт нийт 108 баримтыг нягтлан шалгаж, дотоод товъёог хийж, 2009, 2010, 2011 оны Засаг даргын захирамж, ТГ-ын дарга болон харьяа байгууллагын удирдлагын тушаалыг сканердан CD-д хуулан аймгийн төрийн архивт тушаалаа.	100
Хөтөлбөр 5 Хууль зүйн хүрээний мэдээ, тайланг чанартай гаргаж, хугацаанд нь хүргүүлнэ			
5.1	Хууль зүйн хүрээнд хийгдсэн ажлын тайлан мэдээг Хууль зүйн сайд 2017-07-10-ны А/182 дугаар тушаалаар батлагдсан ажлын үр дүнг үнэлж, дүгнэх журмын дагуу тайлагнана	Багийн засаг дарга нар иргэдэд хууль эрх зүйн чиглэлээр Эрх зүйн сургалт 39 -ыг хийж 859 иргэн цахимаар хандалт хийж, 657 иргэнд биелчэн мэдээлэл хүргэлээ.	70
5.2	Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний зөвлөлөөс батлагдсан журам, гэрээний дагуу Эрх зүйн хөтөчийн ажлыг шалгуур үзүүлэлтээр дүгнэж, нэгдсэн тайлан, мэдээг ирүүлнэ	Эрх зүйн хөтчийн ажлын тайланг 4 агуулгаар хэрэгжилтийг гарган хүргүүллээ.	70
5.3	Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилтийг тайлагнана	Энэ онд ЕБСургуулийн сургалтын менежер 4, сургуулийн захирал 1,цэцэрлэгийн эрхлэгч 1,багийн засаг дарга 5 нийт 11 албан тушаалтны ХАСУМ-ийг цахимаар хянуулан, хуулийн хугацаанд ХАСХОМ-ийг гаргууллаа. Ажлын байрны томилгооны зөрчилгүй ажиллаж, ХАСХОМ гаргагч нар 2019 оны мэдүүлгээ хуулийн хугацаанд цахимаар гаргалаа.Авилга ашиг сонирхолтой холбоотой зөрчил гомдол гараагүй болно.	100
5.4	Шинэчлэн батлагдсан ХАС-ын мэдүүлэг болон ХОМ-ийн тухайн оны тайлан / ХАС-ын мэдүүлгийн хураангуй мэдээлэл, ХОМ-ийн хураангуй мэдээлэл/-г үнэн зөв гаргаж хугацаанд нь тайлагнана	Тайлант онд мэдүүлэг гаргагч 18 албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч хянан баталгаажууллаа.	100
5.5	ХАС-ын мэдүүлэг болон ХОМ гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг үнэн зөв гарган хүргүүлнэ	Сумын ЗДТГазар, харьяа байгууллагуудын ХАСХОМ гаргах 25 албан тушаалтны жагсаалтыг гаргах холбогдох газарт хүргүүллээ.	100
5.6	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг МУЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 5 дугаар	Үндэсний хөтөлбөрийн тайланг журмын дагуу гаргалаа.Хэрэгжилт 88.7 % байна.	70

	хавсралтаар тайлагнана		
5.7	Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг тоо баримтад үндэслэн чанартай гаргаж, тайлагнана	Гэмт хэргийн тоон мэдээллийг улирал бүр Цагдаагийн газраас засаг даргад танилцуулдаг. Гэмт хэргийн гаралт өмнөх онтой харьцуулахад 51 буюу 18.6 % иар өссөн байна. Бусдын бие мах бодид учруулсан гэмт хэрэг өсөлттэй байна. Малчин өрхүүдийн дунд нэг сарын хугацаатай аяны богц аялуулж малын хулгайн гэмт хэргийн мэдээлэл, гарын авлага 20-г тарааж танилцуулга, мэдээллийг цахимаар хүргэлээ. Цахимд 23 өрхийн 157 иргэний тандалттай байна. Малын хулгайн гэмт хэрэг өмнөх оноос 26,3 хувь буурлаа.	70
Хэрэгжилт – 81.53 %			
ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ			
Хөтөлбөр 1 Эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх			
1.1	Явуулын тусламж үйлчилгээгээр алслагдсан сум багийн иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Хөдөөгийн 4 багийн малчдын тойролтоор 4 багийн эмч нар малчдад илгээх захидал явууллаа. Энэ захидалд 10 төрлийн эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл багтсан бөгөөд ундны усны 7 дадал, хуванцар савны тэмдэг тэмдэглэгээ, эрт илрүүлэг, дархлаажуулалт, жирэмсний хяналт, артерийн даралт ихдэлт, сүрьеэ өвчин, малаас хүнд халдварлах халдварт өвчин, Ковид-19 –ийн талаар мэдээлэл багтаасан бөгөөд нийт 160 ширхэгийг хэвлэж, малчдад хүрүүллээ.	100
1.3	“Тэмбүүг устгая 2020” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулах	Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт 703 иргэнийг хамрууллаа. Үүнээс тэмбүү 15, заг хүйтэн 12, триханоз 5-ийг илрүүлж аймгийн нэгдсэн эмнэлгийн БЗДХалдвартын кабинетаар эмчлүүллээ.	100
1.5	Сувилагч хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор сум бүр 1-2 сувилагчийг бэлтгэх талаар хамтран ажиллах	Өлзийт мандал өрхийн эрүүл мэндийн төвийн захиалгаар нэг сувилагч Дорноговь аймгийн Сувилахуйн сургуульд сурч, сумын ЭМТөвийн үйлчлэгч Д.Дуламсүрэнг сувилагчаар бэлтгэн суралцуулах саналыг ЭМГазарт хүргүүллээ.	70
1.6	Иргэдийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэг удаа хамруулж, В, С вирусын илрүүлэлт, эмчилгээг сайжруулж, зонхилон тохиолдох хавдрын өвчлөлийг бууруулах	Элэгний В, С шинжилгээнд-1202 иргэнийг хамруулж, 15% буюу anti-HCV эерэг -50, HBsAg эерэг-42 гарлаа. Артерийн гипертенз илрүүлгийн үзлэгт 1473 буюу 50%, чихрийн шижин хэв шинж 2-т 1380 иргэн буюу 45%, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 1464 буюу 42%, умайн хүзүүний хавдар илрүүлэх PAP шинжилгээнд 644 эмэгтэй хамрагдаж 70,2%-тай байна.	70
1.7	Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэн салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж “ Эрүүл хот, сум, баг, байгууллага, өрх иргэд”-ийг бий болгох “Эрүүл иргэнтэй , Дундговь” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	ЭМС-ын А/472 тоот тушаалын дагуу Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрх шалгаруулах журмын дагуу хөдөөгийн 4 багаас эрүүл мэндийг дэмжигч өрхийг шалгарууллаа. Нийт 8 өрхийн үнэлгээнд шалгуурлалт хийж 4 өрхийг “Эрүүл мэндийн дэмжигч өрхөөр Наран баг- 3. Бямбаа, Тэвш баг- Д.Дугарсүрэн, Далай баг- Х. Бүрэн-Амгалан, Үйзэн баг- С. Бат-Эрдэнэ нарыг шалгарууллаа. Томуу томуу төст өвчний дэгдэлтэй холбоотой зорилтот бүлгийн 9 багийн 51 өрхийн 260 гаруй иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, даралт ихдэлттэй 35 иргэнд даралтын эм, томуу томуу төст өвчтэй 11 иргэн, жирэмсэн 5, жирэмснээс сэргийлэх тариа 3, бэлгэвч 6 хайрцаг, ам зайлах сода, бактерийн эсрэг гарын саван-51, 2 төрлийн гарын авлага тарааж, оношилгоо шинжилгээнд В виурстай-2, С вирустай-2 иргэнд вирус	100

		тоолуулах зөвлөгөө өгч, В вирусгүй иргэдэд В вирусын сайн дурын дархлаажуулалтад хамрагдах талаар зөвлөгөө өгч 370.000 төгрөг зарцууллаа. Сумын ЭМТөвийн чийрэгжүүлэлтийн танхимд тогтмол 16 иргэн хичээллэж байна. Сумын “Эрүүл хот –Эрүүл гэр бүл” дэд хөтөлбөрийн хүрээнд сумын засаг даргын удирдамжаар Сумын ЭМТөв , өрхийн ЭМТөвүүд харъяа байгууллагууд , ХААН банк , МХСГазрын нийт 640 албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх 5 төрлийн үзлэг , шинжилгээ , сургалтанд хамруулж, 318 ширхэг гарын авлага тарааж, ганцаарчилсан зөвлөгөө өгч ажиллалаа. Үзлэгээр элэгний В,С- 13 , хеликобактери-178, сахар -16, илэрсэн ба 3,0 сая төгрөг зарцууллаа. Эрүүл мэндийн төрөл бүрийн мэдээлэл зөвлөгөө, гарын авлагыг 4150 , 8 төрлийн сургалт 3412 албан хаагч хаагч, иргэд хамрагдлаа. Эрүүл амьдрах энгийн алхамууд сургалтыг 17 байгууллагын 724, Ковид-19, АЗДХӨ-өөс сэргийлэх сургалт-350 гаруй иргэдэд мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулж, гарын авлага тараалаа. Эко сав элэг бүтэн амьдрал сэдэвтэй 7 хоногийн арга хэмжээг зохион байгуулж ундны усны дадлын судалгаа, мэдээ мэдээллийн гарын авлага 160 ширхэг гарын авлагыг малчдад тараалаа	
1.9	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, амаржих газрын нярай, хүүхдийн тусламж, үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлж, оношлогоо, эмчилгээний багаж, хэрэгслээр орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хангах	Сумын ЭМТөв, Өлзийт мандал , Боржигон мандал ӨЭМТөвүүдэд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 20,000,000 төгрөгний 9 төрлийн тоног төхөөрөмжөөр хангалаа. Сумын ЭМТ-ийн хүлээлгийн залыг тохижуулж хөтөчийн ширээ, физик эмчилгээний өрөөг иж бүрнээр тохижуулж, хөл, толгой, хүзүү, нурууны массажны аппаратуудыг шинээр ажиллууллаа.	100
Хөтөлбөр 2 Боловсролын бодлогыг хэрэгжүүлэх талаар			
2.1. Сургуулийн өмнөх боловсрол			
2.1.1	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг сум бүр 78,8 хувиас дээш, 5 настай хүүхдийг СӨБ-д хамрагдалтыг 92.2 хувьд хүргэх	2020-2021 оны хичээлийн жилд 8 цэцэрлэгт 2-5 насны 1398 хүүхэд хамрагдаж хамран сургалт 86% байна. Цэцэрлэгт хамрагдвал зохих 1680хүүхдээс тус сумын 1272 хүүхэд хамран сургах тойрогт, 179 хүүхэд Улаанбаатар хот болон өөр аймаг суманд СӨБ-ыг эзэмшлээ. Хамран сургалт 86% байна. 461 хүүхдэд СӨБ-ыг 100 % олголоо. Тус сумын 8 цэцэрлэгт 57 багш СӨБ-ыг олгож, 100% мэргэжлийн багшаар хангагдан ажиллаж байна. 8 цэцэрлэгт мэргэжлийн дуу хөгжмийн 8 багш ажиллаж, 100% мэргэжлийн багшаар хангагдлаа.	100
2.2.Ерөнхий боловсролын сургууль			
2.2.1	“Боловсрол хөгжил”, “Математик” , “Байгалийн ухаан”, “Үндэсний бичиг”, “Хүүхдэд ээлтэй дотуур байр” аймгийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, тайлагнах	Боловсрол хөгжил-98%, Математик-95%, байгалийн ухаан-95%, Үндэсний бичиг-95%, Хүүхдэд ээлтэй дотуур байр-94% хэрэгжүүллээ.	100

2.2.2	ЕБС-ийг мэргэжлийн багш нараар хангах	Тус сумын ЕБ-ын 5 сургуульд 243 багш ажиллаж байна. Мэргэжлийн багшаар 99,4% хангагдлаа.	100
2.2.3	Үндсэн сургалтад хамрагдах аймгийн хэмжээний багш нарыг бүрэн хамруулах	Багшийн мэргэжилт дээшлүүлэх институтын 1 , 5, 10 жилдээ ажиллаж байгаа багш нарын сургалтанд сургуулийн 50 , цэцэрлэг 11 багш 100% хамрагдлаа.	100
2.2.4	Ерөнхий боловсролын сургуулийн бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх	Ерөнхий боловсролын 4 сургуулийн бага ангийн 13 бүлэгт 388 , суурь боловсрол олгох 5 сургуулийн 10 бүлэгт 297 хүүхэд хамрагдлаа.	100
2.2.5	6 настай хүүхдийн хамран сургалтын 93,6 хувь хүргэх	Тус сумын ерөнхий боловсролын 4 сургуульд 459 хүүхэд хамрагдаж , хамран сургах тойргийн харъяалалтай 416 хүүхэд 100% хамрагдлаа.	100
2.2.6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	Тус суманд хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаатай 71 хүүхдээс 37 хүүхэд ЕБС 23 , СӨБ 12 , НТБоловролд 2 хамрагдаж байна. Хамрагдах боломжтой 37 хүүхдийг 100% хамрууллаа.	100
2.2.7	Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөс ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцах хүүхдийн тоог нэмэгдүүлэх	Албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрт 6 суралцагч хамрагдаж байна.2020 оны байдлаар 7 настай 1 сурагч шинээр элсэн суралцаж байна. ЕБСургуульд шилжин суралцсан суралцагч байхгүй.	70
2.2.8	Суурь боловсролын сурлагын амжилтыг үнэлэх 2019 оны чанарын үнэлгээнд үзүүлсэн амжилтыг ахиулах	КОВИД -19" тэй холбоотой арга хэмжээ хийгдээгүй.	70
2.2.9	Бага, суурь, бүрэн дунд боловсролын 2019 оны улсын шалгалтын үзүүлсэн амжилтыг ахиулах	ЭДЦСургууль: Бага- 3,6% , суурь-10,3%, бүрэн дунд -6% өсөлттэй. ГИЦСургууль: Бага-9,1%, Суурь - 35.1% , бүрэн дунд-22,9% өсөлттэй. Хүмүүнлэг Бага 3.3% , суурь-15.7% , Бүрэн дунд 29% өсөлттэй. Цэгцбилиг- Бүрэн дунд 10,8%, суурь 18.68% өсөлттэй. Мандал : Бага 4,1% бууралттай, суурь 20.64%, бүрэн дунд 26,24% Нэгдсэн дүнгээр ЕБС-иудын улсын шалгалтаар бага- 2,9 , суурь -20% , бүрэн дунд - 18,9% байна.	100
2.2.10	Бүрэн дунд боловсролын 2019 оны Элсэлтийн ерөнхий шалгалтаар үзүүлсэн амжилтын оноог ахиулах	2019-2020 оны хичээлийн жилд Элсэлтийн ерөнхий шалгалтанд ерөнхий боловсролын 5 сургуулийн 319 суралцагч хамрагдаж, 2 суралцагч монгол хэлний хичээлээр 800 оноо авсан. ЭЕШ-ын /улс 509, аймаг 491/ сумын дундаж 506 байна. Аймгийн дундажаас 15 оноор илүү байна.	100
2.2.11	Дотуур байранд амьдарч байгаа 6 настай хүүхэдтэй ажиллах туслах багшийг мэргэшүүлэх сургалтад хамруулах	Тус сумын ЕБ-ын 2 сургуулийн дотуур байранд 185 хүүхэд хамрагдсанаас 6 настай хүүхэд 2 байна. ГИЦСургууль 1 багшийг сургалтанд хамрууллаа.	100
2.2.12	Багшийн хөгжлийн төвийн орчин нөхцлийг сайжруулах	Ерөнхий боловсролын сургуулиуд багш нарын ажиллах таатай орчин нөхцөл , ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн багшийн хөгжлийн төвд засвар , тохижилт, техник хэрэгсэлээр хангах ажлуудыг төсвөөр болон хандиваар хийж, 14.5 сая төгрөг	100

		зарцууллаа.	
2.2. 13	Суралцагчдыг түрээсийн сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах	Сургуулиуд 1359 багц номыг 24.8 сая төгрөгийн түрээсийн сурах бичгээр 100% хангагдлаа.	100
2.3.Хүүхдийн хөгжил, хамгаалал			
2.3. 1	Хүүхдийн хөгжлийг дэмжих чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх секц дугуйланг хичээллүүлэх	ЕБС-ийн 5 сургуульд шинээр 12 төрлийн /, залуу химичид, мэтгэлцээн , техникийн загвар, шатар , таеквондо, Цаасан урлал, хар зураг, шагайн харваа, сур харваа, Орон нутаг судлалын клуб/ секц , дугуйланд 625 хүүхэд хамрагдлаа. 2019-2020 оны хичээлийн жилд ЕБС-ийн 5 сургуулийн 98 багш буюу 41% нь секц дугуйлан удирдлаа.	70
2.3. 2	Зарим секц, дугуйланг мэргэжлийн байгууллага, мэргэшсэн иргэдийн оролцоотой хамтран зохион байгуулах	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, БТСГазраас зохион байгуулж буй дугуйлангуудад 381 хүүхэд буюу 11.6% нь хамрагдан чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүллээ.	100
2.3. 3	Суралцагчийн авъяасыг нээн хөгжүүлэх секц, дугуйлан хичээллүүлэх, тэдгээрийн тогтвортой байдлыг хангахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах	ЭДЦСургууль БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 4 ангид 10,9 сая төгрөгийн ширээ сандал хүлээн авлаа. ГИЦСургууль дуу хөгжмийн кабинет шинээр тохижуулан, хөгжмийн зэмсэгээр хангаж 1.000.000, спорт тоглоомын талбайн тохижилтыг улсын төсвийн 178,19 сая төгрөгөөр “Мандал шилтгээн” ХХК гүйцэтгэн ашиглалтанд орууллаа. БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар технологийн кабинетуудыг тоног төхөөрөмжөөр хангаж, засвар , орчин нөхцөлийг хандив тусламжаар тохижууллаа. Хүмүүнлэг сургуулийн багш нар ГБХЗХГ-т төслөөр,9 бүлгэм, клубт 800000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ба 1 сурагчийг улсын тэмцээнд оролцоход 40000, 12 ширхэг сагс волейболын бөмбөгийг 600.000 төгрөгөөр авч суралцагчдыг хөгжих нөхцөл боломжоор хангалаа. Цэгцбилиг сургууль сагсан бөмбөгийн шигшээ багийн сурагчдад хувцас, Уран гоёл арга хэмжээнүүдэд нийт 891000 төгрөг, Сумын ОНХСангийн хөрөнгөөр Цэгцбилиг сургуулийн спорт залны шалыг засварлахад 39.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Мандал сургууль ардын хөгжмийн 2 дугуйланд эцэг эхийн дэмжлэгтэйгээр үндэсний 4 төрлийн 9 хөгжим , урлаг заланд тохижилт хийж нийт 6,7 сая төгрөг , сургуулиуд нийт 8.591.000 төгрөгийг зарцууллаа.	100
2.3. 4	Хүүхдийн хөгжил, оролцооны танхим тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	Тус сумын Ерөнхий боловсролын 5 сургууль тус бүр Хүүхдийн хөгжил, оролцооны танхимтай бөгөөд ЭДЦСургууль БСШУСЯ, “Дэлхийн банк”-аас санхүүжин төслөөр хэрэгжиж байгаа 12,996 сая төгрөгийн хөрөнгө “Гэрэлт ирээдүй” хүүхэд хөгжлийн төв, ГИЦСургууль бага сургуульдаа шинээр Хүүхэд хөгжлийн танхимыг тохижуулан 250000 төгрөг зарцууллаа. Хүмүүнлэг сургууль номын сангаа тохижуулан хүүхдийг тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн , чөлөөт цагаараа шатар, даам тоглох боломжоор хангаж, спорт заландаа хөгжим, сонгон судлах хичээл, секц дугуйлан хичээллэх зориулалтаар 2 өрөө тохижууллаа.	100
2.3.	ЕБС-иудын дотуур байрны гадна	ЭДЦСургуульд 1998 оны Төгсөгчид сургуулийн болон дотуур байрны гадна орчинд	70

5	орчинд тоглоом, чийрэгжүүлэлтийн талбай байгуулах	мод, зүлэг, хүүхдийн тоглоом, нээлтийн индэр гэх мэт 200 сая төгрөгийн бүтээн байгуулалт хийлээ.	
2.4.Насан туршийн боловсролын нэгж			
2.4.1	Насан туршийн боловсролын нэгж болон бусад байгууллагаас зохион байгуулж буй эрүүл мэнд, эрх зүй, ёс суртахуун, мэдээллийн технологи, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад сумын хүүхэд, иргэдийг үе шаттай хамруулах	Эрүүл амьдрах энгийн алхамууд сэдэвтэй сургалтыг 17 байгууллагын 470 ажилчдад зохион байгууллаа. Боловсролын байгууллагуудаас 5 төрлийн цахим хичээл ,3 цахим сургалт хийж, АСЦ-оор болон байгууллагынхаа цахим хаягт байршуулан сурталчиллаа. Цахим хичээл, сургалтанд 6000 /давхардсан тоо /гаруй иргэд , хүүхэд хамрагдлаа.	100
2.4.2	Иргэдийг Амьдрах ухааны хэрэгцээт ур чадвар олгох сургалтад үе шаттай хамруулах	2019-2020 оны хичээлийн жилд Насан түншлэлийн боловсрол нэгж нь нийт 12 суралцагч сургалтад хамрагдаж, сумын 3 сурагч 9 дүгээр ангиа амжилттай төгсөж суурь боловсролын гэрчилгээ авлаа.	100
2.4.3	Насанд хүрэгчдийн авъяас чадварыг хөгжүүлэх дугуйлан, секц, клубт хамруулах	Хорио цээрийн дэглэм тогтоосон тул дугуйлан, секц, клубын үйл ажиллагаа явагдаагүй тул Фэйсбүүкийн цахим хуудсаараа дамжуулан, сургалтын болон спорт, урлагийн контентуудыг түгээж ажиллалаа. Өдөрт 35-40 хүн үзэж тухайн мэдээллийг түгээлээ.	70
2.5.Сургалтын орчин			
2.5.1	Ариутгал, татуургын системд шинээр холбох /улсын төсвөөс бусад эх үүсвэрээр/	Шинээр системд холбогдсон сургууль, дотуур байр байхгүй.	-
2.5.2	Сургуулийн гал тогоог иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах, сайжруулах, засвар үйлчилгээ хийх /улсын төсвөөс бусад эх үүсвэрээр/	ЭДЦсургууль гал тогооны хоолны залны ханыг эко хавтангаар шинэчлэн, 2.2 сая төгрөгөөр засварын ажил, 72 цагийн хоолны дээжийн хөргөгч 1,200,000 төгрөгөөр, ГИЦСургууль 1 төхөөрөмж , 80 сандал, 16 , дотуур байрны гал тогоог засварлахад 1,982000 төгрөг , Хүмүүнлэг сургууль шинээр 1386300 төгрөгөөр 1-р хоолны тогоо, Мандал сургууль 1,2 сая төгрөгөөр шинээр хөргөгч, хөлдөөгч, 3 төрлийн тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийж хоол үйлдвэрлэлийн орчныг сайжрууллаа.	100
2.5.3	Сургууль, дотуур байрыг камержуулах /улсын төсвөөс бусад эх үүсвэрээр/	ЭДЦСургууль бага ангийн 11 ангийг бүрэн камержуулж, 3872000 төгрөг, ГИЦСургууль Хүүхдэд ээлтэй дотуур байрын хөтөлбөрийн хүрээнд 7 камер , хичээлийн “Б” байранд 24 камерыг шинээр байршуулан 8,1 сая төгрөг, Мандал сургууль 1.7 сая төгрөгөөр камержууллаа.	100
2.5.4	Сургуулийн номын сангийн фондын номыг цахим каталогит бүрэн оруулах	Аймгийн номын сантай хамтран сумын ЕБ-ын 5 сургуулийн номын сангийн үйл ажиллагаанд 2 удаа хяналт шалгалтыг зохион байгууллаа. ЕБ-ын 5 сургууль номын тооллого хийж, 7517 номыг үндсэн хөрөнгөндөө бүртгэлээ. ЕБСургуулиуд цахим номын сангийн үйлчилгээнд бүрэн нэвтэрч 7517 номыг цахимд орууллаа. ГИЦСургууль зөвлөмжийн дагуу номын фондны өрөөг тохижуулж, бага сургуульдаа номын сантай боллоо.	100
2.6. Соёлын төв			
2.6.	Соёл, урлагийн үзвэр үйлчилгээг	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Сум хөгжүүлэх сангаас бэлэг	

1	сайжруулах, соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх	дурсгал, зодог шуудаг, оёдол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх 1 ХХК , 2 иргэнд дэмжлэг үзүүллээ.	40
2.6.2	Орон нутгийн соёлын төвийг түшиглэн хүүхэд багачуудын үндэсний хэл соёл, уламжлал, зан заншлаас суралцах, өвлүүлэн хөгжүүлэх чиглэлээр соёлын олон талт ажлыг зохион байгуулах	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, БТСГазраас зохион байгуулж буй дугуйлангуудад 381 хүүхэд хамрагдлаа. ТХДЖТ-аас хэрэгжүүлсэн Ирээдүйн үзэгч зорилтот төслийн хүрээнд 1-9-р ангийн 743 сурагчдад хөгжмийн хичээлтэй уялдуулан ардын болон сонгодог урлагийн лекц концерт, Үндэсний бичгээр үг үсэглэх тэмцээнд 850, эх хэлний өдөр аян 970, “Сургаалын зохиолоос суралцъя” эссэ бичлэгийн улсын уралдаан 205 бүтээл оролцуулж, Хүмүүнлэг сургуулийн МУЗБагш Д.Отгонсүрэн, 10 шавь нарын хамт Монгол бичиг бидний ирээдүй өдөрлөгийг үндэсний бичгийг сурталчилах, туршлага судлах сургалт арга хэмжээг Хулд суманд зохион байгуулж, өөрийн бичсэн “Идэр их мөрөн эх хэлнээ мөрнөө тэмүүлэхүй” дурсамж номны нээлтийг хийлээ.	100
2.6.4	Угийн бичиг хөтөлж хэвшсэн өрхийн тоо	“Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”, аймгийн “Музей” хамтран “ Удам судраа мэдэж, угийн бичгээ хөтөлцгөө ” аяныг зохион байгууллаа. Аянд тус сумын 5 сургууль, 8 цэцэрлэгийн 340 гаруй албан хаагчид хамрагдлаа. 3 байгууллага , 2 иргэнийг шалгаруулж нийт 200000 төгрөг зарцууллаа. Сумын хэмжээнд 476 иргэн угийн бичиг хөтлөж байгаа бөгөөд 2604 өрх буюу 55% нь угийн бичигтэй болсон байна.	70
2.6.5	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус малтлагыг таслан зогсоох, соёлын өвийн зөрчлийн талаарх мэдээллийн мөрөөр арга хэмжээ аварх	Сумын хэмжээнд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 48 газартай. БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ аяны хүрээнд Далай багийн нутагт түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хууль бус малтлагыг таслан зогсоох, соёлын өвийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын хэсэг хяналтыг зохион байгууллаа. Гэрээ байгуулсан хуулийн этгээд байхгүй. Зөрчил гараагүй.	100
2.7. Орон нутаг судлах танхим			
2.7.1	Орон нутгийн иргэдийн түүх соёл, танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор шинээр үзэсгэлэн гаргах	Аймгийн Музейгээс зохион байгуулсан Гар урчуудын бүтээлийн үзэсгэлэнд 8 иргэнийг оролцуулж, 1 иргэн эсгий урлалаар оролцож, тусгай байранд шалгарлаа.	100
2.7.2	Соёлын биет өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох, олон нийтэд таниулах, дэмжлэг үзүүлэх, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулах	Соёлын биет бус өв тээгч 111 иргэн байна. Соёлын биет өвийг өвлөн уламжлагчийг олж тогтоох судалгаа гаргаж, зургийн цомог гаргалаа. Соёлын биет болон биет бус өв тээгчийн талаар цахимаар иргэдэд сурталчилан, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Сум хөгжүүлэх сангаас бэлэг дурсгал, зодог шуудаг, оёдол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх 1 ХХК , 2 иргэнд дэмжлэг үзүүллээ.	70
2.7.3	Түүх,соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сурталчлах арга хэмжээг авах	Аймгийн засаг даргын 1/1001 албан бичгийн дагуу аймгийн Музейтэй хамтран соёлын үл хөдлөх дурсгалуудын хадгалалт хамгаалалтын тооллогыг хөдөөгийн 4 багт хийж ,56 газар тоолж, гэрэл зургаар баримтжууллаа.	100
Хөтөлбөр 3 Гэр бүл, хүүхэд залуучуудын бодлогыг хэрэгжүүлэх талаар			

3.1	Хурдан морины уралдаанч хүүхдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, стандартыг мөрдүүлж ажиллах	Аймаг, сумын баяр наадамд ГБХЗХГ-тай хамтран уралдаанч хүүхэд, уяачид, эцэг эхчүүдэд зөвшөөрөл, гурвалсан гэрээ байгуулах тухай, уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгалын талаар 200 гаруй иргэдэд зөвлөгөө өглөө. Аймаг сумын баяр наадмын үеэр уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах ажлын хэсэгт тус сумын нийгмийн бодлогын мэргэжилтэнүүд хамтран ажиллалаа. Энэ наадамд 6 насны 162 хурдан морь, 74 уралдаанч хүүхдийн мэдээллийг бүртгэлээ.	100
3.2	Сумдын хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах	Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа цахим аяныг зохион байгуулж, 173500 төгрөг, Төсөвт байгууллагууд зорилтот бүлгийн 209 хүүхдийн гэрээр айлчилаа. Бүтэн өнчин 13 хүүхдэд Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүндэтгэл үзүүлж 650000 төгрөг зарцууллаа. Сумын засаг даргын А/202 тоот захирамжаар Манлайлагч хүүхдүүдийг алдаршуулах, тэдний дуу хоолойг сонсох, үе тэнгийнхэнд нөлөөллийн ажлыг зохион байгуулах зорилгоор сумын тэргүүний хүүхдүүдийн “Манлайлал” зөвлөгөөнийг зохион байгуулж, 8-12-р ангийн Манлайлагч 65 сурагч оролцлоо. Суралцагчдаас гарсан санал, санаачлагаар Зөвлөмж боловсрууллаа. Үйл ажиллагаанд 553500 төгрөг зарцууллаа.	100
3.3	Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулах, эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл хүүхдэд хамгааллын үйлчилгээг шуурхай үзүүлэх	Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт 18 өрхийг хамрууллаа. Гэр бүлийн хүчирхийлэл болон үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 108 утсанд ирсэн мэдээллийн дагуу хамтарсан багаар 3 удаа хуралдаж шийдвэрүүдийг гаргалаа. Сумын ГХУСЗөвлөл баяр наадмын үеэр бага насны хүүхэд төөрч алга болохоос сэргийлж эцэг эх, асран хамгаалагчийн утасны дугаарыг тэмдэглэсэн 25 ширхэг бугуйвч тараалаа. Цагдаагийн газраас албан мэдэгдлийн дагуу сумын хамтарсан баг гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 20 гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээг хийж, дунд эрсдэлтэй үнэлэгдлээ. Тухайн 20 иргэний гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүллээ. Гэр бүлийн хүчирхийлэл болон үл хайхрах хүчирхийлэлд өртсөн тухай 108-д ирүүлсэн мэдээллийн дагуу 3 хүүхдэд кейс нээж, хүүхэд гэр бүлд нөхцөл байдлын болон эрсдэлийн үнэлгээ хийлээ.	100
3.4	“Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг иргэдэд сурталчилж, хүүхдүүдийг хөгжлийн хөтөлбөрүүдэд хамруулан чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Өндөржүүлсэн бэлэн байдлын улмаас ажиллаагүй.	-
3.5	Байгууллага аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	Сумын харъяа 16 төсөвт байгууллагад 5-11 хүний бүрэлдэхүүнтэй эцэг эхийн зөвлөл ажиллаж байна. 5-р цэцэрлэг эцэг эхийн зөвлөлтэйгээ хамтран 4 хүүхдэд иж бүрэн хичээлийн хэрэгсэл олголоо. Байгууллагууд шинээр ажилд орсон 56 албан хаагчидтай хүүхэд хамгааллын ёс зүйн гэрээ байгууллаа. Цэцэрлэгүүд Аавуудын өдөрлөг, хүүхэд бидний ирээдүй гар зургийн уралдаан, Ойлгоё, хүндэлье, Үлгэрч аав, ээж, Монгол наадгай, гэр бүлийн үнэт зүйл арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 1300 гаруй эцэг эх оролцлоо. Сургуулийн эцэг эхийн зөвлөл сургалт, ярилцлага, Хүмүүнлэг сургуулийн зөвлөл	100

		анги удирдсан багш нар хамтран цаг үеийн байдалтай холбоотой зөвлөмжүүдийг цахимаар сурталчилан, АСЦ-оор мэдээлэл хийж 208 эцэг эх, сурагчид хамрагдлаа. Цахим хичээл, сургалтанд 7500 /давхардсан тоо /гаруй эцэг эх, асран хамгаалагчид хамрагдлаа.	
3.6	Зорилтод гэр бүлд тулгамдсан асуудлуудыг илрүүлж, гэр бүлийн гишүүдэд хэрэгцээтэй зөвлөгөө, мэдээлэл өгч, нийгмийн суурь үйлчилгээнд холбох	“ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ”-ийг дэмжих туршилтын хөтөлбөрт тус сумаас 18 өрх хамрагдлаа. Өрх тус бүрт багийн нийгмийн ажилтнууд хөгжлийн төлөвлөгөө боловсрууллаа. Сумын “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа” цахим аяны хүрээнд Оюуны гэгээ ТББ-тай хамтран туршилтын 18 өрхөөр айлчилж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, гэр бүл төлөвлөлтийн талаар сурталчилан таниулж, гарын авлага бэлтгэн 18 өрхийн 34 насанд хүрэгчдэд тараалаа. Ахуйн архидалт ихтэй 2 өрхөөр айлчилж эцэг эх асран хамгаалагчид болон хүүхдүүдтэй ганцаарчилсан уулзалт ярилцлагыг зохион байгуулж, хүүхдийн эрх, хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиуд, ГХЗУСэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өглөө. Гэрээр айлчлал хийх үед болон сургууль, цэцэрлэгээс зохион байгуулсан сургалтуудад эцэг эхчүүдийг хамрууллаа. Covid-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа болон зорилтот 18 өрхийн 79 иргэний нарийвчилсан судалгааг гарган, Сумын ЭМТөв , Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран гэр эргүүл, эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа. Үзлэгийн үеэр бага насны-30, өсвөр насны насны 15 хүүхдэд ахуйн осол, цахим гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, цахимыг зөв ашиглах талаар зөвлөмж, мэдээлэлийг өглөө хөнгөн хэлбэрийн ханиадтай -9 хүүхэд, даралт ихсэлттэй-2 асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл өгч 7 хоногт 2 удаагийн давтамжтай үзлэг хийлээ. “Оюуны гэгээ төрийн бус байгууллагаас өрхийн гишүүн бүрт маск, өрх бүрт дархлааг дэмжих аарц өгч, дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, хоол ундны дутагдалд өртсөн 1 өрхөд Улаан загалмай нийгэмлэгтэй хамтран хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлээ. Хөтөлбөрт хамрагдсан хорих ангиас суллагдсан 1 иргэнд халамжийн сангаас олгогддог 1.200.000 төгрөгийн дэмжлэгт хамрууллаа. Архины хамааралтай 1 иргэнийг нийтийг хамарсан ажилд зуучиллаа. Өрхүүдийн насанд хүрэгчдийн 11 иргэнийг байнгын болон түр нийтийг хамарсан ажилд зуучиллаа. Айлд хөлсөөр мал маллаж, морь унадаг өрхийн 2 хүүхэдтэй ганцаарчлан уулзаж, асран хамгаалагчидтай нь хамтын гэрээг байгууллаа.	100
3.7	Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг дэмжиж ажиллах	Хийгдээгүй	0
Хөтөлбөр 4 Биеийн тамир, спортын бодлогыг хэрэгжүүлэх талаар			

4.1	Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит “Токио-Олимп сан”-ийн шилжин явах цомыг орон нутагт аялуулах	Өндөржүүлсэн бэлэн байдлын улмаас ажлаагүй	-
4.2	Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг зохион байгуулж, журмын дагуу үнэлэн, А,В үнэлгээтэй иргэдийн судалгааг БТСГ-т ирүүлэх	Сумын харъяа байгууллагууд бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилыг зохион байгуулж, 418 албан хаагч оролцлоо. Нэгдсэн дүн мэдээг БТСГазарт хүргүүллээ.	70
4.3	ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулагдах аймгийн аварга шалгаруулах тэмцээнд тамирчдаа бэлтгэн оролцуулах	Аймгийн аварга шалгаруулах “Ширээний теннис”-ний тэмцээнд Хүмүүнлэг сургуулийн багш Г.Эрдэнэбилэгийн оролцуулсан баг тамирчид амжилттай оролцож, багаараа тэргүүн байр хүртэн, улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцлоо. "Цодгор хүү 2020" өсвөрийн шатарчдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 11 насны ангилалд Мандал сургуулийн 5-р ангийн сурагч Б. Маргад Тэргүүн байр, 9 насны ангилалд 3а ангийн сурагч Э.Төгөлдөр Тэргүүн байр, 7 насны ангилалд 1в ангийн сурагч Э.Тэмүүлэн гуравдугаар байранд шалгарлаа.	100
4.4	Иргэдийг нийтийн биеийн тамираар хичээллүүлэх арга хэмжээг шат дараатай зохион байгуулах	2-р цэцэрлэгийн нэрэмжит волейболын тэмцээн, ГИЦС-ийн хөл бөмбөгийн талбайн нээлтийн тэмцээнүүдэд 100 гаруй албан хаагчид оролцлоо. Өндөржүүлсэн бэлэн байдлын улмаас Марафон-2020, дугуйн уралдаан, Төсөвт байгууллагуудын албан хаагчдын дунд зохион байгуулагдах Волейболын тэмцээн зохион байгуулагдаагүй.	40
4.5	“Бага олимп” спортын наадамд иргэдийг идэвхтэй оролцуулах	Өндөржүүлсэн бэлэн байдлын улмаас хийгдээгүй.	-
Хөтөлбөр 5 Хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний талаар			
1.1.	Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх заалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих	Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, ёс зүйн талаар 5 байгууллага дотоод журамд нэмэлт заалт оруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүллээ.	100
1.2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчилж, иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх	Дундговь аймаг дахь Хүний эрхийн үндэсний комиссын сургалтанд төрийн албан хаагчид хамрагдлаа. Боловсролын 3 байгууллагын групп, пэйж хуудсуудад 8 төрлийн мэдээллийг байршуулан жендэрийн талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ.	70
1.3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд 23 байгууллага, аж ахуй нэгж ХАБЭА-ын зөвлөл байгууллаа. Төсөвт 15 байгууллага Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэдээллийн самбар ажиллуулж, гарын авлага, цахим видео бэлтгэн мэдээллээ. Мэргэжлийн байгууллагуудаас зохион байгуулагдсан 3 удаагийн сургалтанд 500 гаруй албан хаагчид хамрагдлаа.	100
1.4	Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 35 өрхийг сонгож,	70

	сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	дэлгэрэнгүй судалгааг гаргаж, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 6 өрхийг хамруулан 22,5 сая төгрөгний санхүүжилт олгон өрхийн орлогыг нэмэгдүүллээ. Байнгын ажлын байранд 1, нийтийг хамарсан ажилд 3, түр ажлын байранд 3 иргэнийг, шинээр 2 өрхийн 11 иргэнийг хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт хамрууллаа. Грийн мэпл компаниас ахмад настан 1, ХБИ 6 иргэнд 139000 төгрөгний тусгай хэрэгсэл олголоо. Амьжиргааны түвшинд 21% ахиц гарлаа.	
1.5	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн дагуу мэргэжилтэй ажилтан бэлтгэх, нийтийг хамарсан ажил болон түр ажлын байр бий олгох	Шинээр ажлын байр хайж буй LIMIS программд бүртгэлтэй 71 иргэн байна. Байнгын ажлын байранд 41, түр ажлын байранд 132, улирлын ажилд 1 иргэнийг зуучиллаа. Цаг үеийн байдлаас хамрааран энэ жилд мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалт явагдаагүй	70
Хэрэгжилт – 88.2%			

Хэрэгжилт – 86.17%

ХЯНАСАН:

СУМЫН ЗДТГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНЧИМЭГ

НЭГТГЭСЭН:

ДОТООД АЖИЛТАН:

Э.ЦЭРЭННАДМИД